

**Улаанбаатар цэвэр агаарын санаачлага
II үе төсөл**

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам/ ЕСБХБ

**Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК**

2013 оны 02дугаар сар



Улаанбаатар хотын боловсруулсан агаарын санаачлага 2-р үе

Гэрээний дугаар: 22384/EBSF2009-09-117/01

*Боловсруулсан түлшний хөтөлбөрийн санхүү бүртгэлд
мөрдөх журам*

(Ажлын даалгавар 3.8.9)

2012-9 сар

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ЕСБХБ

БОНХЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
One Exchange Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
0	2013 оны 2 сар	Б.Цэцэнбилэг	Энхээ, Сузанна		
1	2013.03.03	Т.Булган	Энхээ, Сузанна, Онно		

Цэвэр агаарын санаачлага II үе төсөл

Улаанбаатар хотын гэр хорооллуудад халаалт болон хоол унд бэлтгэхдээ муу чанарын нүүрсийг бага бүтээмжтэй зууханд ашиглах нь өвлийн улирлын туршид үргэлжилдэг ужиг агаарын бохирдлын нэг томоохон шалтгаан болж байна. Улаанбаатар хотын агаарын чанар нь оршин суугчдын эрүүл мэнд цаашлаад улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Иймд уламжлалт зуухыг утаа бага ялгаруулдаг зуухаар солих, түүхий нүүрсийг боловсруулсан, нүүрсэн суурьтай, утаа бага ялгаруулдаг, хэмнэлт сайтай түлшээр солих нь тулгамдаад байгаа агаарын бохирдлын асуудлын нэлээд хэсгийг богино хугацаанд шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээний нэг гэж үзэх болсон. Боловсруулсан түлшний найдвартай нийлүүлэлт, түлш, зуухыг хослуулах, тэдгээрийг дэмжсэн хууль эрхзүйн орчин, стандартуудыг боловсруулан гаргах нь уг арга хэмжээг үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай. Засгийн газраас орлуулах түлшний үйл ажиллагааны тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэхийг Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-наас хүссэн юм. ЕСБХБ нь Засгийн газартай 2008 оны 9-р сараас түүхий нүүрсийг боловсруулсан түлшээр орлуулах төлөвлөгөөг боловсруулахаар хамтран ажиллаж эхэлсэн. Уг төлөвлөгөөний үндсэн хэсгийг 2009 оны 6-р сард Засгийн газраар батлуулахаар өргөн барьж, “Түлш орлуулах үйл ажиллагааны бүдүүвч” баримт бичигт тусгасан. Засгийн газар уг баримт бичгийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийг зарчмын хувьд баталж, 2010 оны 6-р сард Монгол Улсын их хурал Агаарын тухай багц хуулиудыг батлаж гаргасаны дараа тус банк төслийн II үеийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болж Үйл ажиллагааны гол хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх Зөвлөхүүдийг шалгаруулж авах ажлыг гүйцэтгэсэн. Зөвлөхүүд нь уг баримт бичгийн холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт хууль эрх зүй, эдийн засаг, техникийн болон бусад чадавхийг бэхжүүлэх шаардлагатай бүхий л тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой.

Энэхүү баримт бичгийг дээр нэр заасан төслийн зорилгын хүрээнд зөвхөн эрх бүхий талуудад зориулан гаргасан болно. Өөр зорилгоор ашиглахыг хориглоно. .

Энэхүү баримт бичгийг ашиглах эрх бүхий талуудаас бусад этгээдүүд өөр зорилгоор ашигласнаас үүдэн гарсан үр дагавар, бусад талуудаас нийлүүлсэн мэдээллийн алдаа мадаг, орхигдсон зүйлсийн талаар манай тал ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү баримт бичиг нь нууц мэдээлэл агуулсан оюуны өмчийн бүтээл болно. Бидний болон энэ баримтыг бэлтгэсэн талын зөвшөөрөлгүйгээр бусад талуудад үзүүлэхийг хориглоно.

Агуулга

Хуудас

ХУРААНГУЙ	VII
1 ОРШИЛ	1
2 ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГААС БОЛОВСРУУЛСАН ТҮЛШНИЙ САНХҮҮЖҮҮЛТЭНД ТАВИГДАХ БҮРТГЭЛИЙН СТАНДАРТ, ЖУРАМ	2
2.1 ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАЖ БУЙ ДҮҮРЭГ.....	2
2.2 НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБА.....	3
2.3 ЦЭВЭР АГААР САН.....	5
3 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН АЖ АХУЙ НЭГЖ, ИРГЭДТЭЙ БАЙГУУЛЖ БУЙ ГЭРЭЭНД ТАВИГДАХ САНХҮҮГИЙН ШААРДЛАГУУД	8
3.1 Түлш нийлүүлэх гэрээ.....	8
3.2 Түрээсийн гэрээ.....	9
3.3 Тээврийн гэрээ.....	9
3.4 Түлш борлуулах гэрээ.....	10
4 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ ХУВЬД САНХҮҮЖИЛТ АВАХАД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ	12
4.1 Борлуулагч.....	12
4.2 Үйлдвэрлэгч.....	12
4.3 Агуулах түрээслүүлэгч.....	13
4.4 Тээвэрлэгч.....	14
5 ЦАС-ГИЙН САНХҮҮГИЙН БУСАД ДҮРЭМ, ЖУРМЫН ТАЛААР	15
5.1 САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР.....	15
5.1.1 Улсын төсвөөс санхүүжилтийн эрх авах.....	15
5.1.2 Санхүүжилтын эрх -ийн үйл ажиллагаанд тавих хяналт.....	16
5.2 ХӨРӨНГИЙГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.....	16
5.2.1 Хөрөнгө зарцуулалтын эрх.....	17
5.2.2 Хөрөнгийн нэмэлт зарцуулалтын эрх нээх.....	17
5.2.3 Бүртгэлийн данс.....	18
5.2.4 Төсвийн байгууллагын бүртгэлийн данснаас зарлага гаргахад тавигдах шаардлага.....	19
5.2.5 Бэлэн мөнгөний үйл ажиллагаа.....	19

Хавсралтууд

Товчилсон үгсийн жагсаалт

ЦАС
НАЧА
Сангийн Яам

Цэвэр агаарын сан
Нийслэлийн агаарын чанарын алба
Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв
байгууллага

Хураангуй

Цэвэр агаарын санаачлага II үе төслийн ажлын удирдамжийн 3.8.9 дэх хэсэгт заасан “Зөвлөх баг нь боловсруулсан түлшний туршилтын хөтөлбөрийн санхүүгийн бүртгэл, тооцооны журам боловсруулах” ажлын даалгаврын хүрээнд боловсруулсан түлштэй холбогдох санхүүгийн харилцааг судлан түүний хүрээнд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмуудыг үндэслэн энэхүү харилцаанд оролцож буй талуудын хувьд дагаж мөрдвөл зохих журмыг нэгтгэн боловсрууллаа.

Боловсруулсан түлшний түгээлтийн механизмийн хүрээнд нэг талаас Засгийн газрын харьяа байгууллагууд, нөгөө талаас аж ахуй нэгж байгууллага, иргэдийн оролцоотойгоор түлшийг нийлүүлэх, түгээх, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд энэ нь Нийслэлийн Агаарын Чанарын Алба (НАЧА) болон Цэвэр Агаарын Сан (ЦАС) нь боловсруулсан түлш үйлдвэрлэгч, тээвэрлэгч, агуулах түрээслэгч байгууллагуудтай гурвалсан гэрээний хүрээнд зохицуулагддаг. Энэ гэрээ нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо иргэдэд хүргэх журам”-ын 2.2 дугаар заалтын дагуу “Захиалагч, нийлүүлэгч, санхүүжүүлэгчийн хооронд гурван талт гэрээ хамтран байгуулна” гэсэн заалтын дагуу хэрэгждэг байна.

Харин түлшний гэрээт борлуулагчидтай НАЧА болон ЦАС-н оролцоогүйгээр дүүрэг дангаараа гэрээ байгуулдаг ба борлуулагч нарыг сонгон шалгаруулахдаа барьцаа төлбөрийн чадварыг үндэслэн, гэрээ байгуулдаг байна.

Боловсруулсан түлшний түгээлтийн одоо хэрэгжиж буй механизмын хүрээнд ЦАС нь түлшний түгээлттэй холбоотой санхүүгийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, харин НАЧА нь түлшийг хүлээн авах, хадгалах, нөөцийн асуудлыг, харин дүүрэг нь борлуулагч нартай борлуулалтын тооцоо хийх, орлогыг цуглуулж ЦАС-гийн дансанд төвлөрүүлэх ажлыг тус тус хариуцан ажилладаг байна.

ЦАС нь үйлдвэрлэгч, тээвэрлэгч, агуулах түрээслэгч нарын төлбөрийг холбогдох баримтуудыг үндэслэн тэдгээрийн данс уруу шилжүүлдэг. Харин НАЧА нь боловсруулсан түлшний нийлүүлэгч болон тээвэрлэгч байгууллагын төлбөрийг баталгаажуулж ЦАС-д төлбөрийг шилжүүлэх тухай хүсэлтийг албан тоот гаргадаг ба хэсгийн ахлагч нарын цалингийн тооцоог ч мөн хийдэг байна. Харин хөтөлбөрт хамрагдаж буй дүүрэг нь борлуулагчидтай тэдний хүлээн авсан түлшний хэмжээ, борлуулалтын тооцоог хянан баталгаажуулах, борлуулагч нарын борлуулалтын хөнгөлтийг тооцох, тэдний дансад тушаасан орлогыг шалган нягтлах, уг орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг нь тооцож, татварын албанд шилжүүлэх зэргийг ажлуудыг хариуцдаг байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 131 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд хяналт тавьж ажиллах орон тооны бус байцаагчийн ажиллах журам”-д зааснаар агаарын бохирдлыг бууруулах хороодын хэсгийн ахлах байцаагч нь түлшний борлуулалтын үнэ, борлуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, түлшний борлуулалтын тооцоог борлуулагч нартай хийн, орлогыг тухайн өдөртөө багтаан ЦАС-гийн дансанд тушааж байх талаар журамласан боловч амьдарлд энэ заалт төдийлэн хэрэгждэггүй байна. Хэсгийн ахлах байцаагч нь дүүргийн ахлах байцаагч нар байдаг эдгээр хүмүүсийн ажил хөдөлмөр эрхэлж байсан туршлага, боловсролын ур чадвар хангалтгүй байдаг тул тэднээр борлуулагч нараас бэлэн мөнгө хураалгаж, ЦАС-гийн дансанд тушаалгах нь тэднийг мөнгө үрэгдүүлэх, ашиглах, завших боломжийг бий болж магадгүй гэж дүүргийн санхүү хариуцсан албан тушаалтнууд үзсэн учир дүүрэг нь шууд борлуулагч нартай

харьцаж, өөрсдөөр нь тухайн өдрийн орлогыг Төрийн сангийн дансанд тушаалгах, тооцоо нийлэх зэргээр энэ ажлыг зохион байгуулан ажилладаг аж.

Боловсруулсан түлшний туршилтын хөтөлбөрийн санхүүгийн бүртгэл, тооцооны журмын одоо хэрэгжиж буй үйл явцад нь тулгуурлан түүнд оролцогч талуудын санхүү, нягтлан бодох бүртгэлийн тайланг бэлтгэх, төлбөр тооцоо хийхтэй холбоотой анхан шатны баримтууд үйлдэх, тайлагнах зэргийг нь одоо хүчин төгөлдөө үйлчилж буй хууль, дүрэм, журмын хүрээнд судалгаа хийж, энэхүү гарын авлага бүхий судалгааг хийсэн болно. Өөрөөр хэлбэл, энэ үйл явцад оролцогч талуудын үйл ажиллагаанд мөрдөглөж буй санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг улам сайжруулахад чиглэсэн ач холбогдолтой судалгаа болно.

1 Оршил


Нийслэлийн Засаг даргын 444 тоот Захирамжаар Нийслэлийн байгаль хамгаалах газрын дэргэд анхлан байгуулагдаж, Засгийн газрын 68-р тогтоол, Нийслэлийн Засаг даргын 14-р тогтоолуудын хүрээнд өргөжиж Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг болсон НАЧА болон Засгийн газрын тусгай сан болох ЦАС нь улсын төсвөөс санхүүждэг төрийн байгууллагууд бөгөөд эдгээр байгууллагууд нь өөрсдийн санхүүгийн үйл ажиллагаандаа УИХ-аас батлан гаргасан хуулиуд, мөн Засгийн газар, түүний харьяа санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас (цаашид “Сангийн яам” гэх) гаргасан тогтоол, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллах ёстой. Иймд НАЧА болон ЦАС-гийн боловсруулсан түлшний санхүүгийн үйл ажиллагаанд дээр дурьдсан хууль, тогтоол, дүрэм, журмын хүрээнд бүртгэл хөтөлөлтийг хийж, тайлагнаж байх ёстой.

Харин бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, тээвэрлэгч, борлуулагч, агуулах түрээслэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэний хувьд Монгол Улсын Татварын багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” болон Сангийн яамнаас батлан гаргасан холбогдох бусад дүрэм, журмуудын дагуу “анхан шатны бүртгэл хөтөлөлт”-ийг гүйцэтгэж, тайлагнах үүрэгтэй.

Цэвэр агаарын санаачлага II үе төслийн баг нь төслийн Ажлын даалгаврын 3.8.9-ийн хүрээнд энэхүү гарын авлага бүхий судалгааг боловсруулахдаа боловсруулсан түлшний санхүүжилт хийхтэй холбогдсон нягтлан бодох бүртгэлийн болон холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлж, НАЧА, ЦАС, мөн дүүргийн ажлын дотоод хэрэгцээнд ашиглах зорилгоор бэлтгэсэн болно.

2 Төсвийн байгууллагаас боловсруулсан түлшний санхүүжүүлтэнд тавигдах бүртгэлийн стандарт, журам

Боловсруулсан түлшний хөтөлбөрийн санхүүжилтийг ЦАС бүрэн хариуцдаг бөгөөд уг санхүүжилтийн үйл ажиллагааны дарааллыг дараах схемээр харуулав.



Дээр оршил хэсэгт дурдсанаар НАЧА нь түлшний нөөцийг хангах, хүлээн авах, хадгалах асуудлыг, харин дүүрэг нь борлуулагч нарын орлогыг цуглуулж, ЦАС-гийн дансанд төвлөрүүлэх асуудлыг тус тус хариуцдаг байна.

2.1 ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАЖ БУЙ ДҮҮРЭГ

Борлуулагч нарын орлогын тооцоо

Борлуулагчид нь дүүрэгтэй байгуулсан гэрээний дагуу өдөр тутмын боловсруулсан түлшний борлуулалтын орлогыг тус дүүргийн төрийн сангийн “Гэрэлтүүлэг, тохижилт үйлчилгээний данс” уруу тушаадаг бөгөөд тэдгээрийн борлуулалтын болон тээвэрлэгчээс хүлээн авсан түлшний хэмжээ, урамшууллын тооцоо зэргийг тус дүүргийн холбогдох нягтлан бодогч нь 7 хоногт 1 удаа нийт 15 цэг дээр очиж тооцоо хийх ба ингэхдээ зохих баримтыг үйлдэнэ. Мөн сар бүрийн эхний 7 хоногийн дотор дүүргийн нягтлан бодогч нь сарын “Боловсруулсан түлшний тооцоо”-г (Хавсралт 1) гаргаж, НАЧА-ны мэргэжилтэн буюу агуулахын нярав болон ЦАС-гийн нягтлан бодогчоор энэхүү тооцоог хянуулж баталгаажуулна.

Борлуулагчид нь тус дүүргийн төрийн дансанд орлогоо тушаахдаа өөрт ногдох тонн тутмаас 6000 төгрөгийн урамшууллыг “Хувь хүний орлогын албан татварын хууль”-ийн дагуу орлогын албан татвар 10%-ийг хасан тооцож, 5400 төгрөгийг өөртөө авч үлдэж болох ба энэ дүнг нийт борлуулсан түлшний тонн тутмаас тооцно. Суутган тооцсон орлогын татварыг хуулийн дагуу сарын бүрийн 10-ны өдрийн дотор дүүрэг тухайн дүүргийн татварын орлогын дансанд шилжүүлж, улирлаар татварын тайландаа оруулж тайлагнана.

Түлшний хөнгөлөлтийн ваучерын тооцоо

ЦАС-гаас олгосон хөнгөлөлтийн ваучерыг дүүргийн зохион байгуулагч нараар дамжуулан хороодын хэсгийн ахлагч нарт тараах бөгөөд хэсгийн ахлагч нар айл өрхүүдэд ваучер бүрийн дугаарыг бүртгэн авч, тараана. Харин борлуулагч нар түлшний хөнгөлөлтийг иргэдэд үзүүлэхдээ энэхүү ваучерыг үндэслэдэг ба мөн ваучерын бүртгэл хөтөлнө. Энэхүү бүртгэлд ваучерын дугаар, айл буюу өрх тус бүрийн 2 тонн кокжсон нүүрс, 1 тонн үртсэн нүүрсийг хөнгөлөлттэй авах эрхээс нь хасч тооцсон тэмдэглэгээ явах юм.

2.2 НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБА

Энэхүү бүртгэлийн журам нь НАЧА-ны ажилтнуудын дагаж мөрдөх журам бөгөөд НАЧА-наас томилогдсон агуулахын нярав нь бараа, материалын бүртгэлийг хүлээн авах байршуулах, аюулгүй байдал, мөн түлшийг ачуулах, түлшний нөөцийг хянах, түлш нийлүүлэгч, агуулах түрээслэгч, тээвэрлэгч нарын төлбөрийг төлөхөд шаардлагатай баримтуудыг бүрдүүлж, шалган ЦАС-д бэлтгэж өгөх үүрэгтэй.

НАЧА нь гэрээний дагуу түлшний нийлүүлэлтэд хяналт тавьж,, түлшийг гэрээгээр тохирсон хугацаандаа нийлүүлэхийг үйлдвэрлэгч нараас шаарддаг ба түлшний стандартын шаардлага хангасан эсэхэд байнга хяналт тавьж ажиллана.

НАЧА нь стандартын шаардлага хангасан дэд бүтэц сайтай, төмөр зам болон авто замтай, байнгын харуул хамгаалалттай, цас, борооны ус нэвтрэхгүй битүүмжлэл сайтай агуулахад түлшийг хадгална.

Түлшний нөөцийг доод тал нь гурав болон түүнээс дээш өдрийнх байлгахгаар тооцоолж түлшний нөөцийн асуудлыг удирдана.

НАЧА нь дээр дурдсанаас гадна дор дурдсан үүргүүдийг мөн хүлээнэ:

- Түлшний бүртгэлийн системтэй байх;
- Бүртгэлийн үйл явц, журмыг байнга сайжруулж, боловсруулах;
- Холбогдох тоо баримт, түлшний бүртгэл тооцооны талаар зохих байгууллага, удирдлагад тогтмол тайлагнадаг байх.

Түлшний бүртгэлийн журам

Агуулахын нярав нь түлшийг нийлүүлэгчээс хүлээж авахдаа нийлүүлэгчийн бэлтгэсэн “Бараа материалын зарлага”-ын баримт, “Нэхэмжлэх”-ийг хүлээн авах ба түлшийг хүлээж авахдаа түүний бүрэн бүтэн байдал, стандарт, савлагаа зэргийг хянан шалгаж түлш хүлээн авсан акт үйлдэнэ. “Бараа материал хүлээн авах баримт”-ыг (Хавсралт-2) 2 хувь үйлдэх ба хүү баримтанд илүү, дутуу тоо хэмжээ, элдэв гологдол байгаа эсэх талаар тэмдэглэл хийж, нийлүүлэгч болон агуулахын нярав гарын үсгээр тус тус баталгаажуулна.

Агуулахын нярав нь хүлээн авсан тоо хэмжээндээ үндэслэн нь “Бараа материалын орлого”-ын баримтыг 2 хувь үйлдэж 1 хувийг нь нийлүүлэгчид талд өгнө.

Агуулахын нярав нь хүлээн авсан хэмжээ болон борлуулах цэг рүү ачуулсан хэмжээ зэргийг харуулсан “Агуулахын бүртгэл” (Хавсралт-3) нийлүүлэгч бүрээр хөтлөдөг ба уг бүртгэлд үндэслэн түлшний нөөцийг хянаж, үйлдвэрлэгчээс түлш хугацаандаа нийлүүлэх талаар шаардлагыг мөн гаргадаг байна.

Сар бүрийн эцэст борлуулагч тус бүрээр түлшний нийлүүлэлтийн талаарх тооцоо гаргаж гэрээний дагуу нийлүүлж байгаа эсэхийг хянаж энэхүү тайланг ЦАС-д өгнө.

Нярав нь гэрээнд зааснаар нийлүүлж буй түлш нь стандартын шаардлага хангаж байгаад хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд түлшийг лабораторын шинжилгээнд оруулж болно. Мөн үйлдвэрлэгчдээс гэрээнд зааснаар хийгдэх лабораторын шинжилгээг шаардаж авна.

Агуулахын нярав нь борлуулах цэг үрүү түлш ачуулахдаа “Бараа материалын зарлагын баримт” болон “Бараа материал хүлээн авах баримт”-ыг тус бүр 2, 2 хувь үйлдэж тээвэрлэгч талд түлшийг тоо ёсоор тулган хүлээлгэн өгөх бөгөөд эдгээр баримтуудыг тээвэрлэгчийн гарын үсгээр баталгаажуулж, 1 хувийг нь өгнө. Энэхүү “Бараа материал хүлээн авах баримт” нь тээвэрлэгчийн тээвэрлэлт хийснийг баталгаажуулах үндсэн баримт болно.

Гэрээний дагуу түлш нийлүүлэгчийн төлбөрийг төлөхөд НАЧА нь нийлүүлэгчээс хүлээн авсан “Нэхэмжлэх”, “Барааны зарлагын баримт” болон няравын үйлдсэн “Орлогын баримт”, “Бараа материал хүлээн авах баримт”-ыг төлбөрийг шилжүүлэх талаарх ЦАС-д хандсан албан тоотын хамт ЦАС-т хүргүүлнэ.

Харин тээвэрлэгчийн төлбөрийг хийхэд НАЧА нь тээвэрлэгчээс хүлээн авсан “Нэхэмжлэх”, няравын үйлдсэн “Бараа материал хүлээн авах баримт” болон тээвэрлэгчтэй 7 хоног бүрийн эхэнд өмнөх 7 хоногийн гүйцэтгэлийг тулган баталгаажуулж тооцоо нийлсэн актыг үйлдэх ба төлбөрийг шилжүүлэх талаарх ЦАС-д хандсан албан тоотод энэ баримтыг хавсаргаж өгнө.

НАЧА нь ЦАС болон дүүрэгтэй хамтран жилийн эцэст агуулах болон гэрээт борлуулагч нарын түлшний үлдэгдлийг тоолох ажлыг зохион байгуулна.

Агуулах, эд хөрөнгийн аюулгүй байдлын журам

Агуулахын нярав нь түрээсийн агуулахын түлхүүрүүдийг хариуцах бөгөөд агуулахаас түлшийг оруулж гаргахдаа ажлын өдрүүдэд 08.00-21.00 цагийн хооронд, амралт, баярын өдрүүдэд 09.00-20.00 цагийн хооронд гүйцэтгэнэ.

Агуулахад түлшийг хураах, байрлуулах зэргийг ажлыг агуулахын нярав хариуцна.

Түрээсийн агуулахын цахилгааны гэмтэл, ус, чийг нэвтрэхээс сэргийлэхэд анхаарч, түрээслүүлэгч байгууллагад шаардлага тавьж ажиллана.

Агуулахын манаач нь агуулахад орсон хүний овог, нэр, огноо, тээврийн хэрэгслийн талаарх тэмдэглэл хөтөлсөн бүртгэлийг хийнэ.

Агуулахыг лац ломбоор битүүмжлэх бөгөөд агуулахад нэвтрэхдээ түүнийг байнга шалгаж байна.

Хэсгийн ахлагч нарын цалингийн тооцоолол

Боловсруулсан түлшний борлуулалтын үнэ, борлуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах орон тооны тус байцаагч нартай НАЧА нь гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд холбогдох журмын дагуу халаалтын 8 сарын туршид сард 50,000 төгрөг урамшуулал олгоно.

Уг урамшууллыг олгохдоо НАЧА-ны санхүүгийн ажилтан нь халаалтын улирлын эхэнд нийт 8 сарын туршид тавьж олгох урамшууллын дүнг ажил олгогчийн төлбөл зохих Нийгмийн даатгалын шимтгэлийн (цаашид “НДШ” гэнэ) 11%-ийг хамт нийтэд тооцон ЦАС-с 9-р сард санхүүжилтийг авах ба байцаагч нарын сар бүрийн ажлын гүйцэтгэлээс хамаарч энэ урамшууллыг олгоно.

Ингэхдээ НДШ 10% болон Хувь хүний орлогын албан татварын 10%-ыг тус тус тооцон суутган авах бөгөөд сарын бүрийн 5-ны дотор суутгасан НДШ-ийг, харин суутгасан хувь хүний орлогын албан татварыг сар бүрийн 10-ны өдрийн дотор тус тус төлж, зохих тайланг сар, улирлаар бэлтгэж тайлагнана.

ЦАС нь 8 сарын дараа НАЧА-тай гүйцэтгэлийн тооцоог хийх ба ингэхдээ олгосон цалингийн хүснэгт, төлбөрийн хуудас бүрийг тулгаж шалгана. Хэрвээ төлөгдөөгүй санхүүжилт үлдсэн бол НАЧА нь ЦАС-гийн данс руу буцааж шилжүүлнэ.

2.3 ЦЭВЭР АГААР САН

ЦАС нь бэлтгэн нийлүүлэгчийн төлбөр тооцоонд хяналт тавих бөгөөд төлбөрийн нэхэмжлэл, бараа материалын орлого, зарлагын баримт, бараа хүлээн авах баримт, тооцоо нийлсэн акт, албан хүсэлт зэргийг НАЧА-гаас хүлээн авсны дараа тухайн хугацаанд багтааж төлбөрийг төлөх үүрэгтэй.

ЦАС нь гэрээт байгууллага, иргэдтэй гэрээний төгсгөлд болон санхүүгийн тайлангийн жилийн эцэст тооцоо нийлсэн акт үйлдэнэ.

ЦАС нь талуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Мөн түлш нийлүүлэгч хуваарийн дагуу түлшээ нийлүүлж байгаа эсэхэд хяналт тавихаас гадна тараагдсан ваучерын тооцоог дүүргээс сар бүр гаргуулан авч нийт хөнгөлөлтийн хэмжээг тооцно.

Түлш нийлүүлэгчийн төлбөр тооцоог хянаж, шилжүүлэх

Түлш нийлүүлэлт бүрийн дараа НАЧА-наас дараах баримтуудыг хүлээн авдаг. Үүнд:

- Бараа материалын орлогын баримт
- Бараа материалын зарлагын баримт
- Түлш хүлээн авсан акт
- Нэхэмжлэх
- Вагоны бичиг баримт (вагонаар ачилт хийгдсэн тохиолдолд)
- НАЧА-н албан тоот

ЦАС нь төлбөрийг шилжүүлэхэд дээрх баримтуудыг тулгаж шалгах бөгөөд эдгээр баримтууд дээр хүлээн авсан, хүлээлгэн өгсөн хүний нэр, гарын үсэг, тамга, тэмдэг байгаа эсэхийг, мөн түлшийг хүлээн авахад аливаа гологдол, дутагдал, шаардлага хангаагүй түлш байгаа эсэхийг шалгана. Түүнчлэн гэрээний дагуу байгаа нийлүүлэлт явагдсан эсэхийг шалгана.

Төлбөрийг төрийн сангаас гаргуулахдаа Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4-р хавсралтаар батлагдсан ТТ-4 маягт буюу “Хяналтын хуудас”-ыг бэлтгэх ба энэхүү жагсаалт дээр бүрдүүлсэн баримтуудыг огноо, дүнгээр нь жагсаасан хуудсыг боловсруулж дээрх баримтууд болон нийлүүлэлтийн гэрээний хамтаар Төрийн санд хүргүүлнэ.

Төрийн сан нь Сангийн яаманд ЦАС-аас гаргаж өгдөг “Гүйлгээний жагсаалт”-д оруулсан эсэхийг нь хянаж нийлүүлэгчийн төлбөрийг Сангийн яамаар хянуулсны дараа төлбөрийг хийдэг.

Агуулах түрээслэгчийн төлбөр тооцоог хянаж, шилжүүлэх

Гэрээнд заасан хугацааны дагуу тухайн сарын төлбөрийг хийх бөгөөд НАЧА-с дараах баримтуудыг хүлээн авна. Үүнд:

- Нэхэмжлэх,
- НАЧА-ны албан тоот.

ЦАС нь түрээсийн нэхэмжлэх гэрээний дагуу үйлдэгдсэн эсэхийг шалгасны дараа төлбөрийг Төрийн сангаар гаргуулахаар Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4-р хавсралтаар батлагдсан ТТ-4 маягт буюу “Хяналтын хуудас”-ыг бэлтгэдэг ба уг жагсаалтанд бүрдүүлсэн баримтуудыг огноо, дүнгээр нь жагсааж дээрх баримтууд болон түрээслэгчийн гэрээний хамтаар Төрийн санд хүргүүлнэ.

Төрийн сан нь Сангийн яаманд ЦАС-аас гаргаж өгдөг “Гүйлгээний жагсаалт”-д оруулсан эсэхийг нь хянаж нийлүүлэгчийн төлбөрийг Сангийн яамаар хянуулсны дараа төлбөрийг хийнэ.

Тээвэрлэгчийн төлбөр тооцоог хянах, шилжүүлэх

Тээвэрлэгч нь 7 хоног бүрийн эхэнд НАЧА-тай тооцоо нийлсэн акт үйлдэж, төлбөрийг нэхэмжлэх ба ЦАС нь НАЧА-гаас дараах баримтуудыг хүлээн авна. Үүнд:

- Тооцоо нийлсэн акт
- Нэхэмжлэх
- НАЧА-ны албан тоот
- Бараа материал хүлээн авах баримт

ЦАС нь төлбөрийг шилжүүлэхдээ эдгээр баримтууд гэрээний дагуу үйлдэгдсэн эсэхийг шалгаж НАЧА-аас борлуулах цэг рүү ачуулсан болон борлуулагч нараар хүлээлгэн өгсөн гарын үсэгтэй “Бараа материалын хүлээн авах баримт”-тай тулгаж үзэх ба түлш тээвэрлэхэд тээвэрлэгчээс хамаарсан аливаа гологдол, дутагдал, шаардлага хангаагүй түлш гарсан эсэхийг шалгана.

ЦАС нь түрээсийн нэхэмжлэх гэрээний дагуу үйлдэгдсэн эсэхийг шалгасны дараа төлбөрийг Төрийн сангаар гаргуулахаар Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4-р хавсралтаар батлагдсан ТТ-4 маягт буюу “Хяналтын хуудас”-ыг бэлтгэдэг ба уг жагсаалтанд бүрдүүлсэн баримтуудыг огноо, дүнгээр нь жагсааж дээрх баримтууд болон түрээслэгчийн гэрээний хамтаар Төрийн санд хүргүүлнэ.

Төрийн сан нь Сангийн яаманд ЦАС-аас гаргаж өгдөг “Гүйлгээний жагсаалт”-д оруулсан эсэхийг нь хянаж нийлүүлэгчийн төлбөрийг Сангийн яамаар хянуулсны дараа төлбөрийг хийнэ.

Борлуулагчийн орлогод тавих хяналт

ЦАС нь түлш борлуулсны орлогыг төрийн санд төвлөрүүлэх үүрэгтэй бөгөөд одоо мөрдөгдөж буй журмын дагуу боловсруулсан түлшний борлуулалтын үйл ажиллагаанд дүүрэгтэй нягт харилцаатай ажиллана.

Сар бүрийн эхний 7 хоногийн дотор “Сарын түлшний тооцоо”-г тус дүүргээс хүлээн авах ба энэхүү тооцоог НАЧА-наас хүлээж авсан “Бараа материалын зарлагын баримт”, “Бараа материал хүлээн авах баримт” болон төрийн дансны хуулгатай тулган шалгаж энэхүү тооцооны хуудсыг баталгаажуулна.

Гэрээт борлуулагчдын түлшний орлого хугацаандаа тушаагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

Түүнчлэн жилийн бүрийн эцэст НАЧА болон дүүрэгтэй хамтран борлуулагч нарын түлшний үлдэгдэлд тооллого хийж борлуулалтын орлого болон түлшний нийлүүлэлтийг тулган баталгаажуулна.

3 Төрийн байгууллага болон аж ахуй нэгж, иргэдтэй байгуулж буй гэрээнд тавигдах санхүүгийн шаардлагууд

НАЧА болон ЦАС нь боловсруулсан түлш үйлдвэрлэгч, тээвэрлэгч, агуулах түрээслэгч болон иргэдтэй Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам”-ын 2.2 дугаар заалтын дагуу “Захиалагч, нийлүүлэгч, санхүүжүүлэгч гэсэн гурван талт гэрээ хамтран ажиллах гэрээ байгуулна” гэсэн заалтын дагуу гурвалсан гэрээг байгуулж байгаа юм. Харин түлшний гэрээт борлуулагчидтай дүүрэг дангаараа гэрээг байгуулах ба борлуулагч нарыг сонгон шалгаруулахдаа барьцаа төлбөрийн чадварыг үндэслэн гэрээ байгуулан ажиллаж байна.

Тухайн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг 2005 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд өөрөөр заагаагүй бол талууд Иргэний хуулиар уг гэрээг зохицуулж байна. Тус хуулийн 40.3-т дараах зүйлсийг зайлшгүй тусгахаар заасан байна. Үүнд:

1. Гэрээний үнэ;
2. Төлбөр хийх нөхцөл, хэлбэр;
3. Урьдчилгаа төлбөр хийх бол урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн, хэлбэр;
4. Захиалагчийн хяналт болон бусад нөхцөл;
5. Гүйцэтгэлийн баталгаа шаардах бол түүний дүн, хэлбэр;
6. Худалдааны нөхцлүүд;
7. Бараа нийлүүлэх, ажил үйлчилгээ гүйцэтгэх хуваарь;
8. Гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал;

Дээрх гэрээний ерөнхий шаардлагад нийцүүлэн санхүүгийн хувьд төлбөр тооцоог хийхэд хэрэгцээтэй мэдээллийн талаар бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэгч тал бүрийн хувьд дараах дэд бүлгээр тайлбарлаж байна.

3.1 Түлш нийлүүлэх гэрээ

Энэхүү гурван талт гэрээний оролцогч талуудад Захиалагч талыг төлөөлж Нийслэлийн Засаг даргын орлогч, түлш нийлүүлэгч талыг төлөөлж тухайн аж ахуйн нэгжийн Гүйцэтгэх захирал, санхүүжүүлэгч талыг төлөөлж ЦАС-гийн Гүйцэтгэх захирал байдаг ба эдгээр албан тушаалтнууд уг гэрээг батална. Харин ЦАС-гийн мэргэжилтэн, НЗДТГ-ын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, НАЧА-н дарга, дэд дарга, мэргэжилтэн болон түлш нийлүүлэгч талын ажилтан нар уг гэрээнд гарын үсэг зурж уг гэрээг байгуулна.

Боловсруулсан түлш нийлүүлэх гэрээнд дараах зүйлсийг тодорхой тусгаснаар харилцагч талуудын хувьд санхүүжилтийг хийхэд чухал ач холбогдолтой.

- Гэрээний хугацаа - талуудын түлш нийлүүлэх хугацаа эхэлснийг үүгээр баталгаажуулна.
- Гэрээний үнэ (нэгж үнэ болон гэрээний нийт дүн) - Энэ нь тонн тутмын үнэ байх ба холбогдох татварууд багтсан эсэх талаар тусгах хэрэгтэй. Түүнчлэн аливаа нэмэлт зардлууд болох сав баглаа боодол, тээврийн зардал, ачиж буулгах зардал, лабораторийн нэмэлт зардал зэргийг нэгж үнэнд орсон эсэхийг тодотгож өгөх нь

үнийн хэлбэлзэлгүй, төлбөр төлөхөд аливаа эргэлзээ гаргахгүй байх ач холбогдолтой.

- Үнийн хэлбэлзэл - Тухайн хугацаанд нийлүүлж буй бүтээгдэхүүний үнэ нь 2 талын тохиролцсон үнэ бөгөөд зах зээл дээрх аливаа үнийн өсөлт, бууралттай холбоотойгоор үнэ хэлбэлзэж болзошгүй байдаг. Энэ тохиолдолд үнийн өөрчлөгдөх нөхцөл, аргачлалын талаар тусгах нь талуудын хооронд гарч болзошгүй маргаанаас сэргийлэх ач холбогдолтой.
- Түлш нийлүүлэх хуваарь - Нийлүүлэгчийн үүргийг тодорхой болгон гэрээний дагуу түлш нийлүүлээгүй хугацаанд алданги хүү тооцоход ашиглагдана. Тодорхой нэр төрөл, нийлүүлэлтийн хэмжээг мөн тусгах хэрэгтэй ба энэ нь нийлүүлэлтийн цар хүрээ хэмжээг илэрхийлнэ.
- Түлшний стандарт, шаардлага - Шаардлага хангаагүй түлш нийлүүлэхгүй байх, аливаа хорогдол гаргахгүй байх нь ЦАС-г үргүй зардлаас зайлсхийхэд тусална.
- Төлбөр хийх нөхцөл - ЦАС-гийн хувьд аливаа төлбөрийг дансаар шилжүүлэх ба төлбөр хийх хугацаагаа тодорхой зааж өгнө. Нэхэмжлэх, лабораторийн шинжилгээний дүн, түлш хүлээн авсан акт, түлшний зарлага, орлогын баримт, НАЧА-ны дүгнэлт, тооцоо нийлсэн баримт зэрэг нь төлбөр хийх үндсэн баримт болох тул эдгээрийг заавал бүрдүүлэх баримт болгон гэрээнд зааж өгөх нь төлбөр хоцруулахгүй байх нийлүүлсэн түлшний хэмжээ, стандарт хангасан түлш нийлүүлсэн талаарх баримт, нотолгоо болох юм.
- Түлш хүргэж өгөх цэгийг тодорхой тусгах - Түлшийг хүлээж авах буюу хүлээлгэн өгөх цэгийг тусгаснаар түлшний эрсдэлийн хариуцлагыг зааглаж ялгаж өгнө.
- Торгууль, алданги, тооцох болон гэрээ цуцлах - Талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.

3.2 Түрээсийн гэрээ

Агуулахын түрээсийн гэрээнд тавигдах дараах санхүүгийн шаардлагууд байна.

- Гэрээний хугацаа - Энэ нь түрээсийн эхлэх хугацаа болон дуусах хугацааг тодорхойлно.
- Гэрээний үнэ - Гэрээний үнэ нь тогтсон үнэ байх холбогдох татварууд багтсан эсэх талаар тусгах хэрэгтэй. Түүнчлэн түрээсийн үйл ажиллагаатай холбоотой цахилгаан, засвар үйлчилгээний зардал гэх мэт нэмэлт зардлууд гардаг бөгөөд эдгээр зардлууд нь түрээсийн төлбөрт орсон эсэхийг тусгаж өгөх нь тодорхой бус байдал үүсэхээс сэргийлнэ.
- Үнийн хэлбэлзэл - Тухайн хугацаанд түрээсийн төлбөр тогтвортой байх эсэхийг тодорхойлох шаардлагатай.
- Төлбөр хийх нөхцөл - ЦАС-гийн хувьд аливаа төлбөрийг дансаар шилжүүлнэ. Түүнчлэн төлбөр хийх хугацааг тодорхой зааж өгөх хэрэгтэй. Түрээсийн гэрээнд төлбөр хийх үндсэн баримт нь гэрээ болон нэхэмжлэх байна.
- Торгууль, алданги, тооцох болон гэрээг цуцлах - Энэ нь талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байдаг.

3.3 Тээврийн гэрээ

Тээврийн гэрээнд тавигдах дараах санхүүгийн шаардлагууд байна.

- Гэрээний хугацаа - Үүнийг гэрээнд тусгаж талуудын ажил үйлчилгээ эхлэх болон дуусгавар болох хугацааг баталгаажуулна.
- Гэрээний үнэ (тонн тутмын үнэ болон нийт тээвэрлэх түлшний хэмжээ) - Энд холбогдох бүх зардал болон татвар орсон эсэхийг тодотгоно.
- Үнийн хэлбэлзэл - Үнийн аливаа өөрчлөлт ямар нөхцөлд гарч болох талаар дурьдах нь үнийн урьдчилан тооцоолоогүй гэнэтийн өөрчлөлт гаргахгүй байхад чухал юм.
- Тээвэрлэлтийн нөхцөл - Тээвэрлэлт хийх хугацаа, ачилтын хэмжээ, тээвэрлэлт хийгдэх цэгүүдийг тодорхойлох нь түлшний ачилтын хувьд бүрэн бүтэн хүлээлгэж өгөх, авах болон түлшний тээврийн нэмэлт зардал гаргахгүй байхад нөлөөлнө.
- Төлбөр хийх нөхцөл - ЦАС-гийн хувьд аливаа төлбөрийг дансаар шилжүүлэх ба төлбөрийг хийхэд нэхэмжлэх, түлш хүлээн авсан акт, түлшний зарлага, орлогын баримт, мөн НАЧА-ны дүгнэлт зэрэг нь төлбөрийг хийх үндсэн баримт болох тул эдгээрийг заавал бүрдүүлэх баримт болгон гэрээнд зааж өгөх нь төлбөр хоцруулахгүй байх, ачсан түлшний хэмжээ, түүний бүрэн бүтэн байдлын талаарх баримт, нотолгоо болох юм.
- Торгууль, алданги, тооцох болон гэрээг цуцлах - Энэ нь талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байдаг.

3.4 Түлш борлуулах гэрээ

Энэ гэрээ нь түлш борлуулагчдыг сонгоход баримтлах Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам”-ын 4 дүгээр зүйлд заасны дагуу дараах хэд, хэдэн шаардлагыг хангасан байх ёстой.

- Борлуулагч нь тухайн хорооны байнгын оршин суугч байх;
- Борлуулах цэг нь 2-3 өдрийн түлшний нөөц агуулах багтаамжтай байх;
- Борлуулах цэгийн байршил нь агаарын бохирдлыг бууруулах салбар хорооны цэгийн төлөвлөгөөнд нийцсэн байх;
- Борлуулагч нь гэрээ байгуулах, үүсэн гарах эрсдэлийг хүлээх чадвартай байх;
- Засаг даргын тодорхойлолтоор борлуулагчийг баталгаажуулсан байх;

Түүнчлэн борлуулалтын гэрээнд тавигдах дараах санхүүгийн шаардлагууд байна.

- Гэрээний хугацаа - талуудын түлш нийлүүлэх хугацаа эхэлснийг үүгээр баталгаажуулна.
- Гэрээний үнэ (нэгж үнэ болон гэрээний нийт дүн) - Энэ нь тонн тутмын үнэ байх ба борлуулсан тонн тутмаас авах татаасыг тусгаж өгөх түүнчлэн холбогдох татварын талаарх үүрэг хариуцлагыг дурьдах хэрэгтэй.
- Барьцаа төлбөр - Борлуулагчдын барьцаа төлбөрийн дүн болон эд хөрөнгийн баталгааны талаар тодорхойлж баримт нотолгоог нь хавсаргах;
- Орлого төрийн санд тушаах - Борлуулагчдын орлого тушаах төрийн сангийн дансыг тодорхой зааж өгөх;
- Хөтөлбөл зохих анхан шатны баримтууд - Түлшний орлогын баримт, ваучерийн бүртгэлийн дэвтэр хөтөлж байхыг мөн түүнчлэн 7 хоног тутамд дүүргийн санхүүтэй тооцоо нийлэн баримт үйлдэж байх талаар зүйлчлэн оруулах;

- Торгууль, алданги, тооцох болон гэрээг цуцлах - Энэ нь талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байдаг.

4 Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хувьд санхүүжилт авахад дагаж мөрдөх журам

Аливаа аж ахуй нэгж, хуулийн этгээд нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайланг гаргахдаа санхүү бүртгэлийн Олон улсын стандартад нийцүүлэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, татварын хуулиуд, Сангийн яамнаас гаргасан бусад холбогдох журмын хүрээнд бүртгэл хөтөлж, тайланг бэлтгэнэ. ЦАС нь боловсруулсан түлшийг үйлдвэрлэгч, тээвэрлэгч, борлуулагч, агуулах түрээслэгчдийн хувьд зөв хөтөлсөн, шаардлага хангасан анхан шатны баримтуудад үндэслэсэн санхүүжилтийг хийх юм. Тиймээс дараах хэсгүүдэд эдгээр байгууллагын боловсруулсан түлшний санхүүжилттэй холбоотойгоор дотооддоо хөтөлбөл зохих анхан шатны баримтууд, тэдгээрийн бүртгэл хөтөлөлтийн шаардлага, стандарт түүнчлэн ЦАС-д бэлтгэж өгөх баримт, тайлангийн талаар дурьдана.

Боловсруулсан түлш үйлдвэрлэгч, тээвэрлэгч, борлуулагч, түгээгчийн хувьд Засгийн газрын 2002 оны 1-р сарын 16-ны өдрийн 11-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор батлан гаргасан Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 6-р сарын 25-ны өдрийн 171/111 тоот тушаалаар баталсан “Өмчийн хэлбэрийн бүх аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх, анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-т суурилсан түлшний бүртгэлийг хөтлөхөд дараах анхан шатны маягтуудыг хэрэглэж болно.

4.1 Борлуулагч

Борлуулагч нарын хувьд бараа хүлээн авах, орлогын тайлан мэдээ бэлтгэхдээ дараах анхан шатны баримууд хөтөлж тайланг гаргах нь зохимжтой юм.

Борлуулагчид нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2011 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам”-д зааснаар үртсэн шахмал түлшийг 1 тонныг нь 80,000 төгрөгөөр, хагас коксжсон шахмал түлшний 1 тонныг нь 90,000 төгрөгөөр тус тус худалдан борлуулж тонн тутмаас 6,000 төгрөгийн урамшуулал авна.

Борлуулагчид нь түлшийг зөвхөн тухайн төлөвлөгөөт хорооны иргэдэд хөнгөлөлтийн ваучерыг үндэслэн борлуулах бөгөөд бусад хорооны иргэдэд худалдахыг хориглоно.

Түлшний тайлан - Түлшний хөдөлгөөнд үндэслэн боловсруулсан түлшний нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр хөтөлсөн орлого болон борлуулалтын хэмжээг тэмдэглэсэн тайлан юм. Энэ тайлан нь дүүргийн санхүүтэй тооцоо нийлэхэд борлуулагчдын хувьд анхан шатны баримт болох юм.

Ваучерын бүртгэл, тооцоо - Энэ тооцооны дэвтэрт хороодоос тараагдсан ваучерын дагуух айл өрхийн хаягийн бүртгэл болон ваучерын дугаарыг тэмдэглэсэн байх бөгөөд энэ бүртгэлийн дэвтэрт үндэслэн ЦАС-гаас олгож буй ваучерын хөнгөлөлтийн тооцоог тулгаж гаргах боломжтой байна.

4.2 Үйлдвэрлэгч

Үйлдвэрлэгчдийн хувьд дотооддоо түлшийг өөрийн үйлдвэрээс агуулахдаа хүлээн авах, худалдан борлуулах, төлбөрийг нэхэмжлэх зэрэг үйл ажиллагаандаа ашиглах анхан шатны баримт болон тайланг бэлтгэхдээ дараах маягтыг ашиглаж болно.

Бараа материал хүлээн авах баримт (НХМаягт БТ-1) - Үйлдвэрлэгч нь өөрийн үйлдвэрээс түлшийг агуулахдаа хүлээж авахдаа дотооддоо энэ баримтыг хөтөлнө.

Орлогын баримт (НХМаягт БТ-2) - Хүлээн авсан бараа материалд үндэслэн энэхүү баримтыг 2 хувь үйлдэж 1 хувийг нь үйлдвэрийн хэсэгт өгнө. Энэ баримт нь нийлүүлэгчийн нэр, байгууллагын нэр болон түлшний нэр төрөл, хэмжих нэгж, тоо, нэгжийн үнэ болон нийт үнийг тусгасан баримт байна.

Зарлагын баримт (НХМаягт БТ-3) - Үйлдвэрлэгчид нь агуулахаас түлшийг гаргахдаа энэхүү баримтыг 2 хувь үйлдэж 1 хувийг тээвэрлэгч талд өгч үлдсэн хувийг санхүүгийн баримт болгон хадгална. Энэхүү баримт нь нийлүүлэгчийн нэр, худалдан авагчийн нэр болон түлшний нэр төрөл, хэмжих нэгж, тоо, нэгжийн үнэ болон нийт үнийг тусгасан баримт байна.

Агуулахын бүртгэл (НХМаягт БТ-5) - Түлш тус бүрийн өдөр тутмын орлого, зарлагын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг тухай бүрт нь мэдэх, түүний бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор агуулахын бүртгэлийг хөтөлдөг бөгөөд энэ нь түлшний орлого, зарлагын баримтад үндэслэгдсэн байх ба тайланг байгууллагын нягтлан бодогч хянаж шалгасан байна.

Бараа материал гаргах зөвшөөрөл (НХМаягт БМ-4) - Түлшний хөдөлгөөнийг эмх цэгцтэй байлгах, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор зөвшөөрлийн хуудсыг аж ахуйн эрхлэгч, нярав нар 1 хувь бичиж үнэ бүхий зүйлийг хүлээн авагчид олгоно. "Бараа материал гаргах зөвшөөрөл"-ийг харуул, манааны хүмүүс ачсан зүйлтэй тулган шалгаж, хураан авч дараагийн ажлын өдөрт санхүүгийн албанд хүлээлгэн өгнө. Зөвшөөрөл нь санхүүгээс тусгай номерлогчоор дугаарлагдсан байна.

Тооцоо бодсон баримт (НХМаягт БТ-7) - Тооллогыг жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө, эд хөрөнгийн хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед, эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед, байгалийн гамшиг, гал түймэр зэрэг гэнэтийн аюулын дараа, аж ахуйн нэгж, байгууллагыг өөрчлөн байгуулсан, татан буулгасан, дампуурсан гэж зарласан зэрэг тохиолдолд хийдэг.

Тооллогын дараа эд хариуцагч нарын тооцоог бодож илүүдлийг орлого болгох ба дутагдлыг төлүүлэх, эсвэл зарлага болгож шийдвэрлэнэ.

Эд хариуцагчийн тооцоо бодсон баримтыг холбогдох нягтлан бодогч 2 хувь нөхөн бичиж тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Баримтын нэг хувь нягтлан бодогчид, үлдэх хувь эд хариуцагчид хадгалагдана.

4.3 Агуулах түрээслүүлэгч

Агуулах түрээслүүлэгчдийн хувьд гэрээнд заасны дагуу харуул, хамгаалалтаар хангаж байгаа нөхцөлд дээр дурьдсан "Бараа материал шалгах зөвшөөрөл"-ийн маягтад үндэслэн түлшийг агуулахаас шалгаж гаргах ба түлшийг агуулахад оруулахад тээвэрлэгч байгууллагын "Барааны зарлагын баримт" болон тээврийн баримт, түлш нийлүүлэгч байгууллагын ажилтны бичиг баримт зэргийг шалган нэвтрүүлж байх юм.

Агуулахын аюулгүй байдал, хяналт шалгалтын зорилгоор харуул хамгаалалтын ажилтан нь өдрийн орсон гарсан тээврийн хэрэгслийн дугаар, тээвэрлэгч байгууллагын нэр, жолоочийн

нэр, мөн бусад орж гарсан хүмүүсийн талаарх мэдээллийг тодорхой цаг хугацаатай нь тэмдэглэл хөтлөж байна.

4.4 Тээвэрлэгч

Тээвэрлэгч байгууллага нь НАЧА-ын хариуцаж буй агуулахаас түлшний тээвэрлэлтийг хийхдээ няраваас “Барааны зарлага”-ын баримт болон “Түлш хүлээн авах баримт”-ыг ачиж буй түлшний нэр төрөл, тоо хэмжээтэй нь хамт хорогдол дутагдалгүй гэдгийг тулгаж, шалгаж авах бөгөөд түлшийг борлуулах цэгт хүргэж өгөхдөө энэхүү баримт дээрээ борлуулагчаас түлшийг бүрэн бүтэн, хорогдолтой байгаа эсэх зэргийг тулган шалгуулж тэмдэглэл хөтлөн энэ баримт дээрээ гарын үсэг зуруулж баталгаажуулж авна.

Бараа материал хүлээн авалтын баримт (НХМаягт БТ-1) - Энэ нь түлшний тоо хэмжээ, сав баглаа боодлын талаар тэмдэглэсэн байх ба маягтыг НАЧА нь 2 хувь үйлдэж 1 хувийг нь тээвэрлэгч байгууллагад өгнө. Энэхүү баримтыг тээвэрлэж буй түлшний тоо хэмжээтэй тулган хүлээн авснаар тээвэрлэгч нь түлшийг хорогдолгүй, бүрэн бүтэн ачиж борлуулах цэг рүү хүлээлгэн өгөх үүрэгтэй болно.

Энэ баримтад үндэслэн ЦАС-д нэхэмжлэл бэлтгэх бөгөөд түүнчлэн нэхэмжлэхийн өмнө ЦАС, НАЧА-тай нийт ачуулсан түлшний тооцоог нийлсэн байна.

5 ЦАС-гийн санхүүгийн бусад дүрэм, журмын талаар

Боловсруулсан түлшний түгээлттэй холбоотой дээрх бүртгэлийн журамд холбогдох талуудын түлшний бүртгэл хөтлөлт болон санхүүжилтийг хийхэд шаардагдах анхан шатны баримтууд, түүнчлэн ЦАС-гаас төлбөр хийхэд Төрийн сан болон Сангийн яамнаас шаарддаг баримтуудын талаар дээр дурдсан билээ.

Түүнчлэн ЦАС-аас аливаа нэхэмжлэлийн дагуу төлбөрийг гүйцэтгэхэд юуны өмнө батлагдсан төсвөөс эрх олж авдаг, түүнийг санхүүжилтээр гаргахад төрийн санд бүртгэлийн данс нээлгэдэг Мөн энэ данснаас санхүүжилт гаргахад тавигдах шаардлагууд хуульд тодорхой заасан байдаг. Харин энэ бүлэгт ЦАС-ийн хүсэлтээр тус сангийн санхүүжилтийн үйл ажиллагааны талаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлагын талаарх голлох заалтуудыг нэгтгэн оруулаа.

Доор дурьдсан журам нь ерөнхийдөө төсөвт байгууллагуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөгдөх журам бөгөөд боловсруулсан түлшний санхүүжилтийг бүрэн хариуцдаг байгууллагын хувьд ЦАС дагаж мөрдөх үүрэгтэй..

5.1 Санхүүжилтийн эх үүсвэр

Боловсруулсан түлшний хөтөлбөрийн санхүүжилтийг ЦАС нь Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу БОНХ-ийн сайдын (цаашид “БОНХ-ийн сайд” гэх) багцад орж батлагдсан улсын төсвөөс батлагдсан хуваарь, журмын дагуу зарцуулдаг.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1.3 дахь заалтын дагуу ЦАС нь хөрөнгийнх нь эх үүсвэрийн зонхилох хэсэг улсын төсвөөс бүрдэх сангийн төрөлд хамаардаг бөгөөд сангийн орлого нь дараах эх үүсвээс бүрддэг.

1. Улсын төсвийн хөрөнгө,
2. Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив,
3. Гадаад улс, олон улсын байгууллагаас ЗГ-ын шугамаар олгосон зээл,
4. Агаарын бохирдлын төлбөр, нөхөн төлбөр,
5. Төрийн сангийн тусгай дансанд байршиж байгаа сангийн хөрөнгийн үлдэгдэлд олгосон хүү,
6. Бусад орлого.

Дээр дурьдсан орлогоос боловсруулсан түлшний хөтөлбөрийг санхүүжүүлэх үндсэн эх үүсвэр бүрэлдэж байгаа юм.

5.1.1 Улсын төсвөөс санхүүжилтийн эрх авах

ЦАС нь боловсруулсан түлшний хөтөлбөрийг санхүүжүүлэгч байгууллагын хувьд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах эрх зүйн үндэс нь санхүүжилт болон зарцуулалтын эрх нээлгэсэнээр эхэлдэг. Энэхүү үйл ажиллагаа нь Сангийн сайдын 2010 оны 48 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай” журам болон Сангийн сайдын 2011 оны 06 сарын 07-ны өдрийн 129 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг нээж, хаах журам”-аар зохицуулагдаж байна.

Сангийн сайдын баталсан төсвийн хуваарийг үндэслэн төрийн сан буюу Сангийн яамны төрийн сангийн газар улсын төсвийн байгууллагын сар, улирлын санхүүжилтийн эрхийн тооцоог хийж, тайлант үеийн эхэнд ЗЭБ-1 (Улсын төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрх олгох жагсаалт) маягтын дагуу баталгаажуулан олгоно.

Ингэхдээ ЗЭБ-1 маягтад Төв төрийн сангийн хувьд Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга нэгдүгээр, Төрийн сангийн газрын дарга 2-р гарын үсгийг зурж, санхүүгийн тэмдэг дарж баталгаажуулсан байна. Ийнхүү баталгаажуулсан ЗЭБ-1 маягтыг үндэслэн Төрийн сангийн газрын төрийн сангийн мэргэжилтэн ЦАС-гийн бүртгэлийн дансанд санхүүжилтийг хуваарилна.

Төрийн сан нь төсөвт байгууллагын хэвийн ажиллагааны бус зардал болон бусад хөтөлбөр, төвлөрсөн, арга хэмжээний зардлын санхүүжилтийн эрхийг холбогдох санхүүгийн баримт нотолгоо, түүнийг санхүүжүүлэх зардлын тооцоо судалгааг үндэслэн батлагдсан төсвийн хуваарь¹-т багтаан шат дараатайгаар эрхийг нээх ба уг эрхийг олгохдоо Сангийн сайдын 2010 оны 48 дугаар тушаалын Хавсралт 2-т заасан хуваарийг мөрдөнө.

Ийнхүү ЦАС-д олгосон санхүүжилтийн эрхийн тооцоог улирал бүр ЗЭБ-6 (Улсын төсвийн байгууллагад олгосон санхүүжилтын тооцоо) маягтаар хийж, дараа улирлын эхний сарын 5-ны дотор Төв төрийн санд хүргүүлнэ. Төв төрийн сан буюу Сангийн яамны Төрийн сангийн газар (цаашид төрийн сан гэх) нь тооцоог хянаж баталгаажуулна².

5.1.2 Санхүүжилтын эрх³-ийн үйл ажиллагаанд тавих хяналт

Энэхүү журамд зааснаас өөрөөр зарцуулалтын эрхийг олгох, төлбөрийг гүйцэтгэхийг хориглох бөгөөд журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Төрийн сан нь өөрийн хариуцсан төсвийн байгууллагуудын санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн гүйцэтгэлд хяналт тавина.

5.2 Хөрөнгийг захиран зарцуулах эрх зүйн зохицуулалт

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-д зааснаар хөрөнгийг нь захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу БОНХ-ийн сайд гаргах бөгөөд сангийн хөрөнгийг гүйцэтгэх удирдлага буюу гүйцэтгэх захирал нь удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу захиран зарцуулах⁴ эрхтэй юм.

ЦАС-гийн хөрөнгийг агаарыг хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах хаягдлыг бууруулах ерөнхий чиг үүргийн дор зарцуулах ба зарим арга хэмжээг ЦАС-гаас санхүүжүүлэх талаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д тодорхой заасан бөгөөд Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан “ЦАС-гийн төсөв бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-д мөн зарим

¹Сангийн сайдын 2010 оны 48 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан төсвийн санхүүжилтын болон зарцуулалтын эрхийн тухай журмын журмын 2.5. “Төсвийн хуваарь” гэж тухайн жилийн төсвийг батлагдсан хууль болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд үндэслэн хуваарилсан төсвийн орлого, зарлагын сар, улирлын батлагдсан хэмжээг;

²Тус журмын 4 дэх зүйл

³Тус журмын 2.6 “Санхүүжилтийн эрх” гэж бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, батлагдсан төсвийн хүрээнд төсвөөс авах санхүүжилтийн дээд хязгаарыг;

⁴“Боловсруулсан агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 6.3, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 13 дугаар зүйл

арга хэмжээг нэмж оруулжээ. Эдгээр үндэслэлээр ЦАС-гийн хөрөнгөөс боловсруулсан түлшний хөтөлбөрийг санхүүжүүлэх эрх зүйн үндэс үүсч байгаа юм.

5.2.1 Хөрөнгө зарцуулалтын эрх

Төрийн сан нь улсын төсвөөс ЦАС-ийн зарцуулалтын эрхийг батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг үндэслэн зарлагын бүлэг болон эдийн засгийн ангиллаар сарын эхэнд системд оруулах ба энэхүү зарцуулалтын эрх тухайн төсвийн жилийн туршид хүчин төгөлдөр байна.

ЦАС нь зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллаар зардал гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн өр, төлбөр үүсгэхгүйгээр хөтөлбөр, арга хэмжээний зорилтыг бүрэн хангахаар төсвийг зарцуулна.

Хэрэв хөтөлбөр, арга хэмжээг бүрэн санхүүжүүлэхэд бараа, ажил үйлчилгээний үнэ тарифийн өсөлт, хөтөлбөрийн шалгуур тоо хэмжээний бодит өсөлтөөс шалтгаалан үйл ажиллагааны батлагдсан төсөв хүрэлцэхгүй тохиолдолд зарлагын бүлэг хооронд гүйлгэн зохицуулах саналыг, тооцоо судалгааны хамт харъяа төрийн санд ирүүлнэ. ЦАС-гаас ирүүлсэн дээрхи саналыг судлан үзээд зайлшгүй зохицуулалт хийх шаардлагатай гэж үзвэл зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд 5,0 сая хүртэлх зохицуулалтыг хийж, ЗЭБ-5 (Төрийн санд хийгдсэн төсөв хоорондын шилжүүлгийн жагсаалт) маягтаар бүртгэн баталгаажуулна.

Сангийн яамны Төрийн сангийн газар нь ЦАС-гаас ирүүлсэн 20,0 сая төгрөг хүртэлх зохицуулалтын саналыг байгууллагын албан хүсэлт, тооцоог судлан зохицуулалт хийх шаардлагатай гэж үзвэл зардлын бүлэг хооронд зохицуулалт хийж, ЗЭБ-5 маягтаар бүртгэн баталгаажуулна. Харин Төсвийн бодлогын газар нь төсвийн ерөнхийлөн захирагч буюу БОНХ-ийн сайдаас ирүүлсэн 20,0 сая төгрөгөөс дээшхи зохицуулалтын саналыг судлан хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулж шийдвэрлэнэ.

БОНХ-ийн сайд нь хагас жил тутам төсвийн байгууллагуудын хугацаа хэтэрсэн өрийг зардлын зүйл бүрээр гарган, өөрийн төсвийн багцын хүрээнд өрийг барагдуулах саналаа Сангийн сайдад ирүүлж болох ба ирүүлсэн саналыг Төсвийн бодлогын газар судлан үзэж төсвийн зохицуулалт хийх боломжтой гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчдын батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг Сангийн сайдад тавьж шийдвэрлүүлнэ.

5.2.2 Хөрөнгийн нэмэлт зарцуулалтын эрх нээх

Төрийн сан ЦАС-гийн бүртгэлийн дансаар дамжин хийгдсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, барьцаа, дэнчингийн төлбөр, ЦАС-д төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон арга хэмжээний санхүүжилт, олон улсын болон гадны байгууллагаас өгсөн хандив, тусламж зэрэг байгууллага хооронд дамжин хийгдсэн төсөл, арга хэмжээний зарцуулалтын эрхийг тухайн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрээс нээж болно.

Дээрх хөрөнгийн зарцуулалтын эрхийг нээхдээ тухайн хөрөнгийг зарцуулах тухай төсвийн байгууллагын албан хүсэлт болон холбогдох гэрээ, шийдвэр, төсөв, түүний нэхэмжлэх зэргийг үндэслэн, хянаж эрхийг нээж төрийн сан сар бүрийн эцэст төсвийн байгууллагад олгосон дээрх хөрөнгийн зарцуулалтын эрхийг ЗЭБ-7 (Улсын болон орон

нутгийн төсвийн байгууллагад олгосон нэмэлт зарцуулалтын эрх) маягаар бүртгэж тайлагнана.

ЦАС төлөвлөгөөнөөс давсан үйл ажиллагааны орлого олсон тохиолдолд тэр хэмжээгээр зарцуулалтын эрхийг шууд нэмэгдүүлэхийг хориглоно.

5.2.3 Бүртгэлийн данс

ЦАС нь дээрхи санхүүжилтийн эрхээ нээлгэсний үндсэн дээр боловсруулсан түлшний хөтөлбөрийн санхүүжүүлтийг тус бүртгэлийн данс⁵-аар дамжуулан хийнэ. Бүртгэлийн дансыг нээж хаах үйл ажиллагаа нь Сангийн сайдын 2011 оны 06 сарын 07-ны өдрийн 129 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын данс нээж, хаах журам”-аар зохицуулагдах ба үйл ажиллагааны онцлогоос хамааран төрийн сангийн бүртгэлийн дараах дансыг дараахь байдлаар ангилна.

1. Төсөвт байгууллагын урсгал санхүүжилтийн данс,
2. Төсөвт байгууллагын хөрөнгө оруулалтын данс,
3. Төсөвт байгууллагын хандив, тусламж, төслийн данс,
4. Улсын төсвийн орлогын данс,
5. Орон нутгийн орлогын данс,
6. Гадаадын зээл, тусламжийн төслийн данс,
7. Засгийн газрын тусгай данс,
8. Орон нутгийн орлогын данс.

Монгол банканд төрийн санд байршуулах боломжгүй дараах дансуудыг байршуулж болно.

1. Төрийн сангийн нэгдсэн данс,
2. Засгийн газрын гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн тусгай данс,
3. Монгол банкинд байршуулахаар заасан Засгийн газрын тусгай данс,
4. Улсын төсвийн валютын данс,
5. Төсвийн байгууллагын гадаад төлбөр, тооцооны данс.

Түүнчлэн төрийн байгууллага нь арилжааны банкинд бүртгэлийн дараах дансуудыг нээлгэж болно.

1. Төрийн сангийн кассын данс,
2. Төсвийн байгууллагын бэлэн мөнгөний үйлчилгээ үзүүлэх байгууллагын картын данс болон орлого төвлөрүүлэх данс,
3. Олон улсын гэрээнд арилжааны банкинд данс нээхээр заасан Гадаадын зээл тусламжийн төслөөр хэрэгжүүлж буй төслийн данс,
4. Хуулинд арилжааны банкинд байршуулахаар заасан Засгийн газрын тусгай зориулалтын данс,
5. Улсын төсвийн орлого, зарлагын валютын данс,
6. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын валютын данс,
7. Улсын болон орон нутгийн төсвийн орлогын тэг үлдэгдэлтэй данс (энэ данс нь өдөртөө төрийн дансанд хаагдах данс).

Төрийн сан нь банкинд нээсэн жагсаалтын нэгдсэн бүртгэлийг тогтмол хийж, дансны мэдээг улирал бүрийн эхний сарын 15-ны дотор төв төрийн санд ирүүлнэ. Төв төрийн сан

⁵Мөн журмын “Бүртгэлийн данс” гэж Төрийн санд байршиж буй төсвийн байгууллагын батлагдсан төсөв зарцуулах эрхийн хүрээнд орлого зарлагын гүйлгээ, санхүүжилтийн эрхийн гүйцэтгэлийг эдийн засгийн ангилалаар бүртгэх дансыг “ хэлнэ.

нь Монголбанк болон арилжааны банкинд нээсэн дансны нэгдсэн бүртгэлийг хийж, хяналт тавьж ажиллана.

5.2.4 Төсвийн байгууллагын бүртгэлийн данснаас зарлага гаргахад тавигдах шаардлага

ЦАС нь боловсруулсан түлшний хөтөлбөрийн хүрээнд төлбөр тооцоог гүйцэтгэхдээ Сангийн сайдын 2011 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 129-р тогтоолоор батлагдсан Төрийн сангийн бүртгэл тооцооны журмын дагуу хийх бөгөөд төсвийн байгууллагын бүртгэлийн данснаас зарлага хийхдээ дараа журмыг баримтлана.

1. Төлбөрийн хүсэлтийг ТТ-1 маягтын дагуу 2 хувь, бэлэн мөнгөний төлбөрийн хүсэлтийг ТТ-2 маягтын дагуу 2 хувь бэлтгэж харьяа төрийн санд төлбөрийн хүсэлтийг үндэслэх баримтын хамт хүргэнэ. Үндэслэх баримтад дараах зүйлсийг хамруулж ойлгоно. Үүнд:
 - Төсвийн ерөнхий менежерийн тушаал, төсвийн задаргааг баталсан хавсралт;
 - Ажил үйлчилгээ гүйцэтгэх, бүтээгдэхүүн худалдан авах гэрээ;
 - Бараа ажил үйлчилгээг хүлээн авсан акт;
 - Нэхэмжлэх;
 - Бараа материалын орлого, зарлагын падаан эсвэл;
 - Өр төлбөр байгааг нотолсон тооцоо нийлсэн акт;
 - Бусад бичиг баримт;
 - Хуулийн дагуу тендер шалгаруулж бэлтгэн нийлүүлэгчийг сонгосон бол Үнэлгээний хорооны шийдвэр;
2. Төрийн сангийн мэргэжилтэн нь дээрх баримтад үндэслэн эдийн засгийн ангилалын дагуу хянаж төлбөрийг гүйцэтгэх бөгөөд ирүүлсэн баримт материал нь шаардлага хангахгүй, батлагдсан төсөв, эдийн засгийн ангиллын дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний хангалттай эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана.
3. Төрийн сан дээр дээрх анхан шатны баримтууд нь шаардлага хангасан тохиолдолд ТТ-1 болон ТТ-2 маягтын 2-р хувь, анхан шатны болон үндэслэх баримтуудад төрийн сангийн мэргэжилтэн гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.
4. Бэлэн мөнгөний хүсэлтийн 1-р хувийг үндэслэн бэлэн мөнгөний чекийн баримтыг төсвийн байгууллагын итгэмжлэгдсэн бэлэн мөнгөний нярав бичилт хийж, төрийн сангийн эрх бүхий албан тушаалтнаар хянуулан, нэг, хоёрдугаар гарын үсэг зуруулж, тамга даруулна.
5. Төрийн сангийн мэргэжилтэн бэлэн мөнгөний чекийн гүйлгээг хийж, чекийн ард гүйлгээ хийснийг баталгаажууан тэмдэг дарж байгууллагын итгэмжлэгдсэн няравт хүлээлгэн өгнө.
6. Төрийн сан төлбөрийн хүсэлт, бэлэн мөнгөний хүсэлтийг үндэслэн төсвийн байгууллагын зардал, өглөгийн бүртгэлийн бичилтийг хийнэ.
7. Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлагатай уялдуулан төсвийн байгууллагын өглөгийг баталгаажуулж, ажлын 3 хоногт багтаан, эцсийн төлбөр гүйцэтгэх эрхийг Сангийн яамны төрийн сангийн газар хариуцна.

5.2.5 Бэлэн мөнгөний үйл ажиллагаа

ЦАС нь арилжааны банкинд данс нээсэнтэй холбогдон бэлэн мөнгөөр орлого хүлээн авах, Төрийн сангийн бүртгэлийн данснаас бэлэн мөнгөний зузаатгал авах, төлбөр тооцоо хийх,

бэлэн мөнгө болон үнэт цаасны зарцуулалтад хяналт тавих, арилжааны банкны төлбөрийн картыг аж ахуйн үйл ажиллагаанд хэрэглэх зэрэг бусад байгууллагуудтай төлбөр тооцоо хийх, харилцах үйл ажиллагаандаа Сангийн сайдын 2010 оны 02 сарын 19-ний өдрийн 39 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх кассын ажиллагааны журам”-ыг мөрдөнө.

Энэхүү журмын дагуу бэлэн мөнгөний гүйлгээг эрхлэх, үнэт цаасыг хадгалах мөнгөн касс ажиллах ба мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх бүхий захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ. Кассын нярав нь дээрх журмын 2 дугаар зүйлд заасан чиг үүргийг гүйцэтгэнэ. Бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар зарлага хийхдээ зарцуулалтын эрхийн баталгаагаар зөвшөөрөгдсөн төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэх бөгөөд төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээнд нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн хязгаарыг дагаж мөрдөнө.

Мөн энэхүү журмаар үйл ажиллагааны орлогоос олох орлогыг мөнгөн кассаа бэлнээр хүлээж авч болох ба ингэсэн тохиолдолд байгууллага нь үүнийг шууд захиран зарцуулахгүй бөгөөд дараагийн ажлын өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд шилжүүлж байхаар заасан байгаа.

Мөн бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлнээр гүйцэтгэх ба төлбөрийн дүн нь 200,000 төгрөгөөс хэтрэхгүй байна. Энэ тогтоосон хэмжээнээс хэтэрсэн болон байнгын харилцан гүйлгээ хийдэг бол төрийн сангийн бүртгэлийн дансаар дамжуулан бэлэн бусаар төлбөрийг хийнэ.

Мөнгөн кассын ажиллагааны холбогдох баримт нь засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан байна. Мөнгөн кассын зарлагын төлбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэгдэн цохолт хийгдсэн байна.

Төсвийн байгууллагын гүйцэтгэх удирдлага нь кассаас гадуур бэлэн мөнгөний орлого цуглуулан авах эрх бүхий ажилтныг томилох бөгөөд энэхүү ажилтан тусгай үйлчилгээний цэг буюу төвлөрсөн кассаар орох бэлэн мөнгөний орлогыг хураахдаа батлагдсан хүчин төгөлдөр маягт, тасалбар хэрэглэнэ. Орлого цуглуулах эрх бүхий ажилтан хураасан орлогоо ЦАС-гийн бүртгэлийн дансанд ажлын нэг хоногт багтаан тушаах ба сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана.⁶

⁶Сангийн Сайдын 2010 оны 02 сарын 19-ны өдрийн 39 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх кассын ажиллагааны журам”-н 3.1-3.6 дахь заалт

Хавсралт 2: Боловсруулсан түлшний тооцооны маягт

БОЛОВСРУУЛСАН ТҮЛШНИЙ ТООЦОО

2-р сарын тооцоо

Д/Д	Түлшний нэр	Ирсэн тоо (тн)	Өндөр үнээр борлогдсон (тн)	Борлогдсон тоо (тн)	Борлуулах нэгж үнэ	Нийт дүн	Өндөр үнээр борлогдсон түлшний дүн	Борлуулагчийн урамшуулал (тонн тутамд)	Борлуулагчийн нийт урамшуулал	ЦАС-д төвлөрүүлсэн мөнгөн дүн	Халамжаар олгогдсон түлшний үнэ (суутган тооцох)	ЦАС-д төвлөрүүлэх мөнгөн дүн
		A=B+C	B	C	D	E=C*D	F	G	H=A*G	I	J	K
1	Хагас коксжсон түлш	2,101.22	31.96	2,069.26	80,000.00	165,540,800.00	4,154,800.00	6,000.00	12,607,320.00	157,088,280.00		28,238,338.00
2	Хагас коксжсон түлш (Шарын гол)	16.87	16.87			-	2,361,100.00	6,000.00	101,220.00	2,259,910.00		
3	Үртсэн шахмал түлш	782.61	56.38	726.22	90,000.00	65,359,800.00	7,893,760.00	6,000.00	4,695,660.00	68,558,188.00		
	Нийт дүн	2,900.70	105.21	2,795.48		230,900,600.00	14,409,660.00		17,404,200.00	227,906,378.00	-	28,238,338.00

Тооцоо гаргасан нябо

Ж.Болорчимэг

/Дүүргийн нябо/

Хянасан

Э. Эрдэнэбаатар

/ НАЧА-ны мэргэжилтэн/

Баталгаажуулсан нябо

М. Хулан

/ ЦАС-гийн нябо/

Хавсралт 3: Бараа материал хүлээн авалтын баримт

Хавсралт 4: Нэмэлт тэмдэглэл

Гэрээний нэр	Улаанбаатар Боловсруулсан агаар санаачлага – II үе – Төслийн хяналт удирдлага
Тайлангийн нэр:	Монгол улсын Улаанбаатар хот дахь түлшний түгээлтийгсудлах
Захиалагч	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Захиалагчийн гэрээний Дугаар	C22384/EBSF-2009-09-117/01
Захиалагчийн холбогдох мэдээлэл	БОАЖЯ, Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газар Засгийн газрын байр II Нэгдсэн Үндэстний гудамж 5/2 Улаанбаатар хот-210646 Монгол улс
Зөвлөх	Евроконсалт Мотт Макдоналд Амстердамсевег 15, Арнхем Шуудангийн хайрцаг 441 6800 АК Арнхем Нидерланд улс Утас: +31 (0) 26 357 7111, Факс: +31 (0) 26 357 7577 И-мэйл: euroconsult@mottmac.nl , вeб хуудас: www.euroconsult.nl
Гэрээний менежер/ Төслийн захирал	Каролин ла Чапелл И-мэйл: caroline.lachapelle@mottmac.nl
Багийн ахлагч/ Төслийн менежер	Пиет де Вилдт И-мэйл: piet.wildt@mottmac.nl